


## СОНГИНО

### Ач холбогдол



	<p>Хоолыг амт чанартай болгоод зогсохгүй хоолны шингэц, нойр, биеийн дархлааг сайжруулна. Мөн үе мөчний өвчнөөс сэргийлэхэд нөлөөтэй</p>
---	--

**Сорт.** Сонгино нь 2 ба олон настай ургамал. Сонгиныг бөөрөнхий, урт ногоон, тагар, алтайн зэрлэг сонгино гэж ангилна. Үүнээс бөөрөнхий сонгины Бессоновский, Стригуновский зэрэг сортууд манай оронд нутагшсан.


**Ургах нөхцөл.** Хөнгөн элсэрхэг хөрсөнд сайн ургана. Говийн бүсэд тарьж зах зээлд нийлүүлэхэд илүү тохиромжтой. Харин урт ногоон сонгино нь олон настай учир талбайд нь өвөлжүүлээд хавар эрт услаж ургуулан шинээр нь хүнсэнд хэрэглэх буюу худалдаанд гаргах боломжтой.

**Хөрс боловсруулалт.** Үржил шим муутай талбайд тариалах бол 1 м.кв талбай тутамд 8-10 кг орохоор тооцож бүрэн ялзарсан бууцаар бордоно. Сонгино тарих хөрсийг урд намар нь хүрзний эн далд ортол гүн хагалаад тэгшилж өвөлжүүлнэ. Хавар тарихын өмнө 8-10 см урт шүдтэй маажуураар дахин сийрүүлж хайрцаг хийнэ. Хайрцагны урт нь 2-5 м, өргөн нь 1,5 м-ээс ихгүй байна. Хайрцагны доторхи хөрсний гадаргуу нь тэгш байх нь чухал. Хэрвээ тэгш биш бол усалгаа жигд биш болж сонгино жигд ургахгүй. Хайрцаг хийж дуусаад хөрсийг 20-40 см гүнд нэвтэртэл сайн услана.

### Үрийг бэлтгэх.

	<p>А. Тарих үрийг 24 цагийн турш 25-30 хэмийн халуун бүлээн усанд дэвтээнэ. Дэвтээх явцдаа усны температурыг бууруулахгүй байхад анхаарч 3-4 цаг тутамд усыг сольж үе үе хутгана. 24 цагийн дараа үрээ шүүж аваад ноосон даавуунд боож чийгийг нь алдагдуулахгүйн тулд гадуур нь гялгар уутанд хийгээд 20 хэмийн дулаантай газар 1-2 хоног байлгаж соёолуулна</p>
	<p>Б. Төл сонгиноор бөөрөнхий сонгино ургуулахад зөөлөрч муудаагүй зөв хэлбэртэй 1-2 см-ийн голчтой хэсгийг сонгож авна. Сонгож авсан төл сонгиноо дулаан гэрэлтэй газар бүлээн усаар жигд чийгшүүлэн норгож 2-3 өдөр эртжүүлнэ.</p>


### Тарилт.

	<p>Сонгиныг хар үрээр, төл сонгиноор, үрсэлгээр тариална. Тарихын өмнө хөрсийг нэвчитэл усалсан байна. Хэрэв усалгаа хийж амжаагүй бол үрээ суулгасны дараа бага зэрэг нягтруулаад зөөлөн аргаар хөрсөө нэвтэртэл услана. Үр болон төл сонгиныг гараар ба зориулалтын үрлэгчээр суулгана.</p>
---	---

Сонгины төрөл	Тарих хугацаа	Эгнээ хоорондын	Ургамал хоорондын зай	Үр суух гүн /см/
---------------	---------------	-----------------	-----------------------	------------------



		зай /см/	/см/	
Бөөрөнхий сонгино	4/20-5/15	20-25	8-10	4-5
Тагар сонгино	4/20-5/15	20-22	6-8	4-5
Урт ногоон сонгино	4/20-8/15	18-20	2-3	1-1.5

### Ээлжлэн тариалалт.




**Арчилгаа.** Ургалтын явцад услах, хөрс сийрүүлэх, зэрлэг устгах өвчин хортонтой тэмцэх зэрэг арчилгаа хийнэ. Сонгино тариалсанаас хойш хур бороо ороогүй бол хар үрийн сонгиныг 3-5 хоногийн дараа, төл сонгиныг 10-14 хоногийн дараа тус тус 2 дахь усалгааг хийнэ. Сонгиныг ургалтын хугацаанд 6-8 удаа услана Усалгаа ихдүүлбэл булцуу ялзарч өтөх зэрэг сөрөг үзэгдэл бий болно.

Шим тэжээл дутмаг хөрсөнд тарьсан бол 200 литрийн төмөр торхонд 60 кг орчим үхрийн шинэ баасыг хийж 7-10 байлгасны дараа 10 дахин шингэлж бордоод шууд услана.

	Усалгаа бүрийн дараа мөр хооронд сийрүүлэлт хийнэ. Энэ нь хог ургамал устгах, хөрсний агааржилтыг сайжруулах, сонгины булцууг томруулах, хөрсний чийгийн алдагдлыг багасгах, усалгаагаар өгсөн ус ба хур борооны усны ашиглалтыг сайжруулах зэрэг ач холбогдолтой.
	Булцуу томрох үед нь хөрсийг сайн суллаж өгнө. Бөөрөнхий сонгины усалгааг 8-р сарын дунд үеэс зогсоогоод ишийг нугалж налуулна. Ингэснээр булцуу эрчимтэй томорч хальсжилт сайжирна.

**Хураалт, хадгалалт.** 1м.кв талбайгаас 3кг бөөрөнхий сонгино хураана.

	Бөөрөнхий ба төл сонгиныг булцууны хүзүү нарийсч иш навч нь шарлан хатсан хойно хураана. Хураасны дараа сүүдэр газар дэлгэн хатааж чанараар нь ялгаад. Зооринд 15 см–ээс зузаангүйгээр дэлгэж хадгална. Урт ногоон сонгиныг байшингийн хонгил, дээвэр мэт газар хөлдөөж хатаагаад хэрэглэж болно. Мөн давсалж хадгалж болно.
---	--